

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬААТЫН ГАЗРЫН БАРУУН БУС ДЭХ ГАЗРЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ А.БУЛГАНТАМИРЫН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	
	1	2	3	4	5	6	7
НЭГ. "ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ БОЛОН БУСАД ХУУЛИЙН ДАГУУ АЙМАГ, ОРОН НУТГИЙНХАА ХЭМЖЭЭНД ГАДААДЫН ИРГЭНД ХЯНАЛТ ТАВИХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	Арга хэмжээ №1.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг харьяалах орон нутагаа зохион байгуулах, дүнг нэгтгэн байгууллагын удирдлагад танилцуулах, хэрэгжилтэд хяналт тавих;	Холбогдох хуулийн болон хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна.	0%	50%	Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 3 удаа тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор 13 байгууллага, аж ахуйн нэгжийн 11 орны 155 гадаадын иргэн хамрагдсан. Мөн байгууллагын даргын баталсан төлөвлөгөөт хяналт шалгалтыг бүсийн хэмжээнд зохион байгуулж, Шалгалтад Бүсийн хариуцсан хэсгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 13 хөдөлмөр эрхэлж, ажиллаж буй болон хувийн хэргээр оршин суугч, түр ирэгч 15 /Австрали, Англи, АНУ, Бразил, Вьетнам, Герман, Дани, Канад, Казахстан, Нигер, Норвеги, Орос, Солонгос, Хятад, Филиппин/ орны 422 гадаадын иргэн хамрагдлаа.	01-06	
2	Арга хэмжээ №1.2. Хилийн боомт, орон нутаг зорчих гадаадын иргэн, баримт бичигт үзлэг шалгалт хийх, шаардлагатай гадаадын иргэнтэй ярилцлага хийж, тэмдэглэл хөтлөн баталгаа гаргуулах;	Хил нэвтрүүлэлгүй буцаасан болон хил нэвтрэхэд хяналт тавьсан	0%	50%	Булган боомтоор хил нэвтэрсэн 15 орны 1657, Бургастай боомтоор 1 орны 11771, Боршоо боомтоор 1 орны 51651, Тэс боомтоор 1 орны 105, Арцсуурь боомтоор 1 орны 2863, Байтаг боомтоор 1 орны 57, нийт 15 орны 68104 /Орос, Беларусь, Казахстан, Хятад, Литва, Франц, Сингапур, Япон, Нидерланд,	01-06	

	1	2	3	4	5	6	7
		байна.			Итали, Их Британи, Герман, Америк, Испани, Энэтхэг/ гадаадын иргэнд хяналт тавьж ажилласан.		
3	Арга хэмжээ №1.3. Хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хянан шалгаж, төвд шийдвэрлүүлэхээр уламжлах, хяналт тавих;	Гадаадын иргэн, аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлсэн байна.	0%	50%	Хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хүсэлт ирүүлээгүй.	01-06	
4	Арга хэмжээ №1.4. Орон нутгийн төмөр зам, авто зам болон агаарын тээврийн хэрэгслээр зорчигч гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, баримт бичигт үзлэг шалгалт хийх, хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхтэй гадаадын иргэний хөдөлгөөн болон хилийн бүсэд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлж буй эсэхэд хяналт тавих ажил шатахууны зардлын асуудлаас шалтгаалан тухай бүр нь хийгдээгүй, зарим аж ахуйн нэгж байгууллагад оршин суух зөвшөөрөлтэй, түр ирэгч гадаадын иргэдийн судалгааг и-мэйлаар авч баяжилт хийсэн.	Гадаадын иргэдийн зорчих хөдөлгөөнд хяналт тавьсан байна.	0%	50%	Орон нутгийн төмөр зам, авто зам болон агаарын тээврийн хэрэгслээр зорчигч гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, баримт бичигт үзлэг шалгалт хийх, хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхтэй гадаадын иргэний хөдөлгөөн болон хилийн бүсэд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлж буй эсэхэд хяналт тавих ажил шатахууны зардлын асуудлаас шалтгаалан тухай бүр нь хийгдээгүй, зарим аж ахуйн нэгж байгууллагад оршин суух зөвшөөрөлтэй, түр ирэгч гадаадын иргэдийн судалгааг и-мэйлаар авч баяжилт хийсэн.	01-06	
5	Арга хэмжээ №1.5. Монгол Улсаас албадан гаргасан, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэний зорчих хөдөлгөөнд хяналт тавих.	Эрх хязгаарлагдсан гадаадын иргэдийг бүрэн хянасан байна.	0%	50%	Ховд аймгийн нээлттэй, хаалттай 457 дугаар хорих ангид ял эдэлж байгаад суллагдсан Казахстаны 1 иргэний талаар албадан гаргах дүгнэлт бичиж удирдлагад танилцуулан, байгууллагын даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/09 дүгээр тушаалын дагуу Баян-Өлгий аймгийн Цагааннуур олон улсын авто замын боомтоор 2023 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр албадан гаргаж, гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргасан тухай тодорхойлолт үйлдэж, Зөрчил шалган шийдвэрлэх газарт хүргүүлсэн.	01-06	

1	2	3	4	5	6	7
				Зөрчил шалган шийдвэрлэх газраас албадан гаргаж байгаа Оросын 1 иргэнийг Увс аймгийн Боршоо авто замын боомтоор гаргах үед хяналт тавьж, гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргасан тухай тодорхойлолт үйлдэж, Зөрчил шалган шийдвэрлэх газарт хүргүүлсэн. Монгол Улсаас 2018 онд албадан гаргагдсан, орохыг хориглосон хугацаа дуусаагүй Оросын 1 иргэн, Монгол Улсад нэвтрэх виз, визийн зөвшөөрөлгүй хил дээр ирсэн Хятадын 3 иргэн, нийт 2 орны 4 иргэнийг хил нэвтрүүлэлгүй буцаасан.		
ХОЁР. "ЗӨРЧИЛ ГАРГАСАН УРИГЧ, ГАДААДЫН ИРГЭНИЙ ТАЛААР МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЖ, ЗӨРЧИЛ ШИЙДВЭРЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД						
6	Арга хэмжээ №2.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийг зөрчсөн хүн, хуулийн этгээдийн зөрчлийг шийдвэрлэх, шийдвэрлэлтэд хяналт тавих;	Хуулийн хэрэгжилт хангагдаж, зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэсэн байна.	0%	50%	гадаадын хөрөнгө оруулалттай ХХК-д С1 хэлбэрээр оршин сууж байгаа БНХАУ-ын 3, "ХХК-д С1 хэлбэрээр оршин сууж байгаа БНХАУ-ын 9, нийт 1 орны 12 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалтад зааснаар хүн тус бүрийг 10 нэгж буюу 100,000 төгрөг /нийт 1,200,000 төгрөг/-өөр торгож, шийтгэл ногдуулсан.	01-06 92
7	Арга хэмжээ №2.2. Хуульд заасан үндэслэлээр гадаадын иргэнийг саатуулах, бичиг баримтын бүрдүүлэлтэд хяналт тавих;	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	0%	50%	Хуульд заасан үндэслэлээр гадаадын иргэнийг саатуулах ажиллагаа хийгдээгүй. Монгол Улсад байх визийн хугацааг хэтрүүлсэн Австрийн 2 иргэнийг төвд хүргэх ажиллагаанд хяналт тавьсан.	01-06 90
8	Арга хэмжээ №2.3. Хяналтын улсын байцаагчийн зөрчил шалган шийдвэрлэлтэд хяналт тавих, буруу шийдвэрлэсэн тохиолдолд зөвтгөх санал гаргах;	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд алдаа дутагдал	0%	50%	Хуульд заасан хугацаанд гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийг мэдүүлээгүй уригч 2 аж ахуйн нэгжийг Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.1 дэх заалтад	01-06 92

	1	2	3	4	5	6	7
		гаргахаас урьдчилан сэргийлсэн байна.			зааснаар нийт 660,000 төгрөгийн торгууль шийтгэл оногдуулсан хяналтын улсын байцаагчийн зөвшчил шалган шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан.		
9	Арга хэмжээ №2.4. Хяналтын улсын байцаагчийн гадаадын иргэнийг албадан гаргах тухай дүгнэлтийн эрх зүйн үндэслэл, албадан гаргах ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих;	Албадан гаргах үйл ажиллагаа зохих журмын дагуу явагдсан байна.	0%	50%	Монгол Улсаас 2018 онд албадан гаргагдсан, орохыг хориглосон хугацаа дуусаагүй Оросын 1 иргэн, Монгол Улсад нэвтрэх виз, визийн зөвшөөрөлгүй хил дээр ирсэн Хятадын 3 иргэн, нийт 2 орны 4 иргэнийг хил нэвтрүүлэлгүй буцаасан.	01-06	
10	Арга хэмжээ №2.5. Зөрчил гаргасан хүн, хуулийн этгээдэд зөрчил арилгуулах талаар албан шаардлага, гаргах сануулга өгөх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих;	Хүн, хуулийн этгээдийн гаргасан зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэсэн байна.	0%	50%	Гадаадын иргэнд хүргүүлсэн гарах сануулга байхгүй, гадаадын иргэн, түүний уригчид 1 албан шаардлага хүргүүлсэн.	01-06	
11	Арга хэмжээ №2.6. Хариуцсан нутагт үйл ажиллагаа явуулдаг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэний объектын судалгаа, бүртгэлийг хийж, тухай бүр баяжуулах, хяналт тавих.	Аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэнийг судалгаанд бүрэн хамруулсан байна.	0%	50%	2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн ББ-2024/14-01 дүгээр төлөвлөгөөт хяналт шалгалтанд хамрагдсан 8 байгууллага, аж ахуйн нэгжийн объектын судалгааг шинэчилэн, баяжилт хийж, Ховд аймагт оршин сууж байгаа 9 аж ахуйн нэгж, байгууллагын 10 орны 58 гадаадын иргэнийг объектын судалгааны "хяналт шалгалтын сан" программд бүртгэж оруулсан.	01-06	
ГУРАВ. "ВИЗ, ЗӨВШӨӨРЛИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ, МЭРГЭЖИЛТНИЙГ МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН УДИРДЛАГААР ХАНГАЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
12	Арга хэмжээ №3.1. Виз, зөвшөөрөл, харьяатын ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч, мэргэжилтний виз олгох, сунгах, түр ирэгчийн бүртгэл хасалт хийх зэрэг үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;	Албан хаагчид мэргэжил, арга зүйн удирдлагаар хангагдсан байна.	0%	50%	Хариуцсан хэсгийн Булган авто замын боомтод виз, зөвшөөрлийн газраас ирүүлсэн 51 удаагийн визийн зөвшөөрлийг үндэслэн Хятадын 199 иргэнд зохих ангилал, төрөл, зориулалтын виз олгосон. Хятадын 1 иргэнд энгийн зэргийн, К1 ангиллын, олон удаагийн төрөлтэй, орох	01-06	

	1	2	3	4	5	6	7
					зориулалттай визийн шилжүүлэг хийсэн хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нарын ажиллагаанд хяналт тавьсан.		
13	Арга хэмжээ №3.2. Олон Улсын болон гадаадын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар, Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх, иргэний харьяаллын асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;	Холбогдох хуулийн дагуу үйлчилгээ үзүүлсэн байна.	0%	50%	Монгол Улсын харьяат болон харьяатаас гарах харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан иргэн байхгүй. 48 цагийн бүртгэл хийлгэхээр ирсэн түр ирэгч Казахстаны нийт 41 иргэний мэдээллийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн сантай тулгах ажиллагаанд хяналт тавьсан.	01-06	93
14	Арга хэмжээ №3.3. Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийн талаар албан хаагчдад сургалт, мэдээлэл зохион байгуулах;	Албан хаагчдын мэдлэг чадвар дээшилсэн байна.	0%	50%	Шинээр боловсруулагдаж буй, хууль, журмын төсөлд 8 удаагийн саналыг хүргүүлж, батлагдсан хууль журмуудаар 5 удаагийн сургалт, мэдээллийг хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нарт хийсэн.	01-06	93
15	Арга хэмжээ №3.4. Виз, зөвшөөрөл, харьяатын ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч, мэргэжилтний үйл ажиллагаанд ашиглаж буй тэмдэг, дардасны бүртгэлийг хөтөлж хяналт тавих;	Тэмдэг, дардасны хяналт холбогдох журмын дагуу тавигдсан байна.	0%	50%	Виз, зөвшөөрөл, харьяатын ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч, мэргэжилтний үйл ажиллагаанд ашиглаж буй тэмдэг, дардасны бүртгэлийг хөтөлж хяналт тавьж, шинээр хяналтын улсын байцаагч болсон 1, мэргэжилтнээр томилогдсон 3 албан хаагчид тэмдгийг хүлээлгэн өгсөн.	01-06	95
ДӨРӨВ. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
16	Арга хэмжээ 4.1. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоолын шийдвэрийн хэрэгжилт, шаардлагаатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох нэгж, албан хаагчид хүргүүлэх	Хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна.	0%	50%	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулж, төлөвлөгөөний биелэлтийг хагас жил тутам гаргаж үнэлүүлсэн. Хяналт шагалт, виз зөвшөөрөл, иргэний харьяаллын тайланг сар бүр гаргаж төвийн холбогдох газарт, хэлтэст хүргүүлсэн. Харилцан ажиллагаатай хууль, хүчний байгууллагад гадаадын иргэдтэй холбоотой 9 удаагийн тоон мэдээллийг цаг тухайд нь гаргаж хүргүүлсэн.	01-06	94

	1	2	3	4	5	6	7
17	Арга хэмжээ 4.2. Албан хэргийн хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна.	0%	50%	Едос системээр 9 албан бичиг хүлээн авч 10 албан бичгийг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлсэн. Иргэнээс 1 гомдол мэдээллийг хүлээн авч төлөвлөгөөт бус хяналт зохион байгуулж, дүнг танилцуулсан. Байгууллагын холбогдох газар хэлтсээс дотоод албан бичиг 10-г хүлээн авч холбогдох хариуг боловсруулан хүргүүлсэн. Ховд, Завхан, Говь-Алтай, Увс аймгууд дахь хилийн ангиудтай 2024 онд хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.	01-06	95
18	Арга хэмжээ 4.3. Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх;	Хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна.	0%	50%	Удирдлагаас өгсөн хууль ёсны 18 үүрэг даалгаврыг биелүүлтүхай бүр нь биелүүлсэн.	01-06	93
19	Арга хэмжээ 4.5. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох	Хамт олны гар нийлэмжтэй ажиллагаа хангагдсан байна.	0%	50%	Байгууллага болон холбогдох бусад байгууллагаас зохион байгуулсан тэмцээн уралдаан, монгол бичгийн тэмцээн, нийтийн хамарсан хурал, олон нийтийн ажилд идэвхтэй оролцсон.	01	90

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	
1	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Өргөдөл гомдлын хариу албан бичгийн төслийг	1	3	4	5	6	7
		2	100	Албан бичгийн төсөл боловсруулан удирдлагад танилцуулж хобогдох байгууллага	Монгол Улсын иргэн ирүүлсэн гомдол мэдээллийн хариу албан бичгийн төслийг төлөвлөн удирдлагад танилцуулан боловсруулж	01	93

	1	2	3	4	5	6	7
	боловсруулах			албан тушаалтанд хүргүүлсэн байна	хүргүүлсэн.		
2	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Ирсэн албан бичгийн хариу төслийг боловсруулах	Албан бичгийн төсөл боловсруулах	100	Албан бичгийн төсөл боловсруулан удирдлагад танилцуулж хобогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлсэн байна	Увс, Говь-Алтай, Завхан аймгийн Прокурорын газраас ирүүлсэн эрх бүхий албан тушаалтнуудын судалгааг гаргаж хүргүүлсэн.	01	93
3	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Төвөөс болон орон нутгаас ирүүлж буй судалгаанд хамрагдах	Судалгаанд хамрагдах	100	Байгууллагуудаас ирүүлж буй судалгаанд идэвхитэй хамрагдсан байна.	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 8 удаагийн сургалтад цахимаар хамрагдсан. Байгууллагын дагуу төвөөс төлөвлөгөөний дагуу сургалтын онлайнгаар зохион байгуулсан 6 удаагийн, дотооддоо 3 удаагийн сургалтыг удирдамжийн дагуу зохион байгуулахад хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлэн ажилласан.	01-06	93
4	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Ирсэн албан бичгийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагааг зохион байгуулах	Байгууллагын нэр дээр гэр барих	100	Тавигдах шаардлагын дагуу иж бүрэн гэр барих ажлын зохион байгуулсан байх	Ховд аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/82 тоот албан бичгийн хүрээнд байгууллагын нэр дээр тавигдах шаардлагын дагуу иж бүрэн гэр барих ажлын бүрэн зохион байгуулж "Мөнгөлөг шагшуурга" цас, мөсний баяр дууссаны дараа хураан байршуулсан.	01	90
5	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Ажлын үнэмлэх, читон, тамга үнэмлэх, читон, тамга тэмдэг, лацны хадгалалтын бүрэн байдлыг шалгуулах	Ажлын үнэмлэх, читон, тамга тэмдэг, лацны хадгалалтын бүрэн байдлыг шалгуулах	100	Ажлын үнэмлэх, читон, тамга тэмдэг, лацны хадгалалтын бүрэн байдлыг шалгуулсан байна.	Ажлын үнэмлэх, чөтөн, тамга тэмдэг, лацны хадгалалтын бүрэн бүтэн байдлыг шалгуулаж, захиргааны ахлах мэргэжилтэнд ажлын хуучин үнэмлэхээ хураалгаж шинэ үнэмлэх хүлээж авсан.	01-02	90
6	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6. Ирсэн албан бичгийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагааг	Биеийн тамирын сорилд албан хаагчдыг	100	Нийт албан хаагчид бүрэн хамрагдсан байна.	Ховд аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 01/489 тоот албан бичгийн хүрээнд 03 дугаар сарын 27-ны өглөөний 07:00-08:00	03	


	1	2	3	4	5	6	7
	зохион байгуулах	бүрэн хамруулах			цагийн хооронд бүсийн төвийн нийт албан хаагчдыг БТСГ-т биеийн тамирын сорилд бүрэн хамруулсан.		49
7	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7. Сар бүрийн эхний 5 хоногт багтаан статистик мэдээг гаргаж хүргүүлэх	Мэдээний хариу өгөх	100	Холбогдох байгууллагыг мэдээллээр хангах	Ховд аймгийн Статистикийн хэлтэст үйл ажиллагааны сарын мэдээг нэгтгэн хүргүүлсэн.	01-06	95
8	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 8. Ховд аймгийн Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулсан олон төрөлт спортын тэмцээнд оролцох	Спортын арга хэмжээнд оролцох	100	Спортын арга хэмжээнд оролцож амжилт үзүүлсэн байна.	Ховд аймгийн Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулсан олон төрөлт спортын тэмцээнд Ховд аймгийн Шүүхийн байгууллагатай хамтран оролцож Буудлага, шагайн харвааны төрөлд хүрэл медалийн болзол хангасан.	03	90
9	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 9. Байгууллагын ойн төглийн хашааг сэргээн босгож, нэмж мод тарих	Төгөл сэргээх, мод тарих	100	Байгууллагын ойн төгөлийн хашааг сэргээн босгож, нэмж мод тарьсан байна.	Бүсийн газрын албан хаагчидтай хамтран бүсийн газрын 2021 онд байгуулсан ойн төглийн хашааг 40 гаруй шон суулгаж торлон 30 ширхэг модыг нэмж тарин усалгааны суваг шуудууг нэмж татан сэргээсэн.	06	80
10	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 10. Шинэ байранд нүүж орох, хуучин ГХБХБГ-ын байрыг хүлээлгэн өгөх	Байрны тохижилтын ажлыг зохион байгуулах	100	Албан хаагчдын ажиллах таатай орчин бүрдсэн байна.	2023 оны 12 дугаар сарын 10-20-ны хооронд шинэ албаны байранд нүүж орох, ГХБХБГ-ын байрыг засварлан хүлээлгэн өгсөн.	12-01	95
11	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 11. Уулзалт зөвлөгөөнд оролцох	Зөвлөгөөнд оролцох	100	Албан хаагчдын албаны мэдлэг дээшилнэ.	Монгол Улсын Үндсэн хуулийн шинэчилсэн найрууллагын танилцуулгад 4 албан хаагчийн хамт оролцсон.	01	93
12	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 12. Бүсийн газрын танилцуулга бэлтгэх	Танилцуулгыг шинэчлэн боловсруулах	100	Удирдлагыг үнэ зөв, цаг үеийн мэдээллээр хангасан байна.	Бүсийн газрын танилцуулгын 3 удаа шинэчлэн боловсруулж танилцуулсан.	01-06	95
13	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 13. Хилийн боомтод ажиллах албан	Тушаал боловсруулах	100	Хилийн боомтын үйл ажиллагаа хэвийн явагдана.	1, 2 дугаар улиралд хилийн боомтод ажиллах албан хаагчдын хуваарийг боловсруулан батлуулж, үүрэг	1, 3	95

хаагчдын боловсруулан батлуулах	хуваарийг боловсруулан батлуулах	Хэрэгжилтийг хангах		Үйл ажиллагаанд тавих хяналт сайжирсан байна.	гүйцэтгэлтэд нь хяналт тавьж ажилласан.		
14	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 14. Хилийн боомтуудад албаны үйл ажиллагааны дэвтрийг хүргүүлэх	Хэрэгжилтийг хангах	100	Үйл ажиллагаанд тавих хяналт сайжирсан байна.	Хилийн Булган, Бургастай, Боршоо, Тэс, Арцсуурь боомтуудад тус бүр 2 ширхэг албаны үйл ажиллагааны дэвтрийг хүргүүлсэн.	01, 02	94
15	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 15. Сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулах	Сургалтыг хугацаанд нь зохион байгуулах	100	Албан хаагчдын мэдлэг чадвар дээшилнэ.	Дэвшин томилогдсон мэргэжилтэн шинээр томилогдсон нарыг албанд дадлагажуулах төлөвлөгөөг боловсруулан батлуусан.	01-03	93
16	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 16. Оршин суугаа иргэдийн мэдээллийг шинэчлэх	Бодит мэдээлэлтэй болох	100	Шинэчилсэн үнэн зөв судалгаагаар болсон байна.	2024 оны 02 дугаар сарын 09-ны өдрөөс хойш ISM бүртгэлийн программ ажиллахгүй болсон тул сүүлийн мэдээллүүдийг шинэчлэн виз олгосон бүртгэлтэй тулгаж шинэчилсэн.	03-04	90
17	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 17. Байрны гадна талбайд зүлэгжүүлэлт хийх	Цэцэрлэгжүүлэлтэй болох		Байгууллагын гадна талбайд өнгө үзэмж сайжирна.	Албан хаагчидтай хамтран зүлэг тарих хэсгийн чулууг түүж бэлтгэл ажлыг хангасан.	05	98
18	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 18. Завхан аймгийн Тэс боомтын цогцолборыг барихад санал хүргүүлэх	Шинэ байртай болох		Албан хаагчийн амьдрах орчин нөхцөл сайжирсан байна.	"ДУКАТ" ХХК-ий захиралд албаны болон амьдрах байрны талаарх саналын хүргүүлсэн.	01	95

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	
1	Арга хэмжээ №1.1. Шинээр болон шинэчлэн найруулагдан батлагдсан хууль, тогтоомжуудыг тухай бүр уншиж, судлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх	Шинээр батлагдсан хууль, тогтоомжийг тухай бүр уншиж судалсан байна.	0%	50%	Шинээр боловсруулагдаж буй, хууль, журмын төсөлд 8 удаагийн саналыг хүргүүлж, батлагдсан хууль журмуудаар 5 удаагийн сургалт, мэдээллийг хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нарт хийсэн. Мөн өөрийн биеэр судалж хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн.	01-06	90
2	Арга хэмжээ №1.2. Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи зэрэг төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдах	Өөрийн мэдлэгийг дээшлүүлж сертификатай болсон байна.	0%	50%	Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи зэрэг төрийн болон төрийн бус байгууллагаас сургалтын санал ирээгүй. Онлайнаар зангиа.мн сайтаас өөрийн мэдлэгийг дээшлүүлэн сертификат авсан.	01-06	80
3	Арга хэмжээ №1.3. Хятад хэлний мэдлэг чадвараа дээшлүүлэх	Мэдлэг дээшилсэн байна.	0%	-	2024 оны 4 дүгээр улирлаас суралцах бодомжтой байгаа болно.	01-06	

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



А.БУЛГАНТАМИР 2024 оны 06 сарын 13 өдөр